

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

**Ковид-19 халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх чиглэлээр:**  
Батлагдсан 282 тохиолдол бүртгэгдэж, тайлант хугацаанд PCR шинжилгээг 6342, антиген түргэвчилсэн оношлуураар 4924 хүнд тус тус шинжилгээ хийсэн байна.

05 дугаар сарын 01-ны өдрөөс 1-р тун, 5 сарын 21-ний өдрөөс 2-р тунгийн дархлаажуулалтыг эхлүүлж аймгийн хэмжээнд нийт хамрагдвал зохиох 37536 хүнээс 1-р тунд 31954 буюу 85.0 хувь, 2-р тунд 15665 буюу 42.8 хувийг нь вакцинд хамруулаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссын хуралдааныг 8 удаа хуралдуулж, нийт 34 асуудал хэлэлцэж, 34 төрлийн шийдвэр, 1 удаагийн албан даалгавар гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын хуралдаанаар Гамшгийн сангаас оны эхнээс өссөн дүнгээр 78826,9 мянган төгрөгийн санхүүжилт авч коронавирусийн шинжилгээ хийх, хамар залгиурын оношлуур 3932 ширхэг, 2200 хос үзлэгийн бээлий, N-95 хаалт 200 ширхэгийг бэлтгэн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэн, дархлаажуулалттай холбоотой зардал, вакцин тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэлээ.

Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын байгууллагаас коронавирусийн халдвараас сэргийлэх вакцин, дагалдах хэрэгсэл, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл эм, тоног төхөөрөмж нийт 3472713.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Эрүүл мэндийн газрын 2021 оны А/19 дүгээр тушаалаар харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хуваариллаа

Коронавирусийн халдварын өвчлөлийг эмчлэх, халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд нийт 14 төрийн болон төрийн бус байгууллага, 15 иргэн нийт 171058.6 мянган төгрөгийн хандив өгсөнийг Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/27, А/28 дугаар тушаалаар харьяа эрүүл мэндийн байгууллагууд, өндөржүүлсэн бэлэн байдлын үед хамтран ажилласан байгууллагуудад хуваарилан, тайланг аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн Онцгой комиссын хуралд 5 удаа танилцуулан мэдээллээ.

НҮБ-ын хүүхдийн сангаас Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээнд нэн шаардлагатай 7 нэр төрлийн 11 эмнэлгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүллээ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт нярайн амьсгалын аппарат, өвчтөний зөөврийн монитор-3, автоклав, датчиктай пульсоксметр, тариурын болон дуслын автомат шахуурга тус бүр-1, алслагдсан 3 сумд нярайн шарлалт хэмжигч, 1 сумд автоклавыг хуваарилан хүлээлгэн өглөө.

Эрүүл мэндийн яамнаас 32500.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт орж

ирснээс коронавируст халдвар үед тохиолдлын эмчилгээ оношилгоонд ажилласан 6 эрүүл мэндийн байгууллагын 65 ажилтанд олголоо.

Батлагдсан тохиолдлын хавьтал 816 хүний судалгаа гаргаж 6 дахь хоногийн шинжилгээнд 728, 13 дахь хоногийн шинжилгээнд 716 хүн хамрууллаа. Энэ хугацаанд ЗӨСҮТ-ын явуулын шинжилгээний баг 6318, нэгдсэн эмнэлгийн Genexpert аппаратаар 48 нийт 6366 ПГУ шинжилгээ хийлээ.

Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга О. Амгаланбаатар 05 дугаар сарын 12-ны өдөр 18 сумын Засаг даргатай коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлаар цахим хурал хийж, холбогдох алба хаагчдад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын газраас зохион байгуулсан цаг үеийн мэдээ мэдээллийг Онцгой байдлын газрын [www.ga.nema.gov.mn](http://www.ga.nema.gov.mn) цахим хуудаст 2 удаа, орон нутгийн “Миний нутаг” телевизээр 12 удаа ярилцлага, мэдээлэл хийж, иргэдэд хүргэлээ.

Тайлант хугацаанд нийт 4 удаагийн гал түймрийн дуудлагыг хүлээн авч, 3 гал түймрийн дуудлагыг зөрчлийн мэдээгээр бүртгэж, 1 гал түймэр дээр гал унтраах тархалт хийж, 8000 литр гал унтраах бодис, 60 литр шатахуун зарцуулж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад 215.0 сая төгрөгийн хохирол учирч, 10.0 сая төгрөгийг авран хамгааллаа.

2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 13 цаг 45 минутаас 17 цаг 32 минут хүртэлх хугацаанд тус аймгийн Есөнбулаг сумд 28-36 м/с, Бугат, Тонхил сумд 22-26 м/с, Чандмана, Шарга сумд 18-20 м/с, Хөхморьт, Цээл сумд 16-18 м/с, Гуулин тосгонд 17 м/с тус тус хүрч, хүчтэй шороон шуурга шуурсны улмаас Есөнбулаг сумын иргэдээс гэр, хашаа нурсан, байшингийн дээвэр хууларсан, барилгын гадна өнгөлгөөний хэсэгт нуралт, эвдрэл үүссэн, автомашинуудын цонх, шил хагарсан зэрэг нийт 106 дуудлага мэдээллийг хүлээн авч, ашиглах боломжтой болон боломжгүйгээр дүгнэлт гаргалаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны тавдугаар сарын 25-ны өдрийн 130 дугаар зарлигаар “Эхийн Алдар” I, II зэргийн одонг 189 ээжид гардуулж, хүндэтгэл үзүүллээ.

Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах, байгууллагын ажилтан алба хаагчдын гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмжтэй зүй зохистой харьцах чадварыг дээшлүүлэх зорилгоор гал унтраах тархалтын сургуулийг Алтай, Дэлгэр, Тайшир, Халиун сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангид цахим хэлбэрээр зохион байгуулж 125 ажилтан хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Гамшгийн шуурхай удирдлагын газар, Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас ирсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар авч, 4 удаа 13320 иргэнд, коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаа, 5420 иргэнд багц мессежээр, байгууллагын вэб хуудас, аймгийн 8 фэйсбүүкээр мэдээллийг байршуулж мэдээлсэн ба “Миний нутаг” телевизээр 2 удаагийн давтамжтайгаар

хүргэлээ.

“Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх нь” төслийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэх цахим уулзалтыг зохион байгуулсан ба эрүүл мэндийн салбарт төрийн хөрөнгө санхүүг зохистой зарцуулж төрийн үйлчилгээ, төрийн хөрөнгө оруулалтын үр дүнг нэмэгдүүлэхэд оршино. Төслийн энэхүү шатанд иргэний нийгмийн болон төрийн байгууллагын мэдээлэл ашиглах, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг нэмэгдүүлэн ажиллах юм

Монгол УУСын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, тус яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Барилгын хөгжлийн төвийн дэд захирал ГХБХБГазар, Ундарга-Алтай ААТҮГазар мөн Аймгийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцан, барилгын салбарт тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өглөө.

Тус бүрэлдэхүүнд ажилласан Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тархвар судлаач эмч М.Оюунчимэг, Эмнэлзүйч эмч Б.Туяацэцэг, Сувилагч Ж.Түмэнжаргал, Жолооч С.Дугарсүрэн нарыг хүн ардын эрүүл мэндийн төлөө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэнд талархлаа илэрхийлж, Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнаж, хүндэтгэл үзүүллээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтын холбоос, сургалтын талаарх мэдээллийг И-Оффис системээр 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр бүх сум, агентлагийг албан хаагчдад хүргүүллээ.

Коронавируст халдвар “Ковид-19”-ын эсрэг вакцинаар дархлаажуулалтын судалгааг Эрүүл мэндийн газар, сумын Засаг даргын Тамгын газраас авч нэгтгэн явцын хяналт-шинжилгээ хийлээ. 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 1 дүгээр тунд хамрагдвал зохих иргэдийн 81.77% нь буюу 31065 иргэн, 2 дугаар тунд 10.8% нь буюу 4065 иргэн хамрагдсан байна. Нийт иргэдийн 15.7% нь буюу 5968 иргэн вакцинд хамрагдахааргүй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт аймгийн цаг үеийн мэдээлэл, аймгийн эдийн засаг нийгмийн үзүүлэлтүүдийг гаргаж хүргүүллээ.

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2016 оноос өмнө гарсан болон хэрэгжүүлэх хугацаа өнгөрсөн, агуулга нь давхацсан Засгийн газрын 17 шийдвэрийг хяналтаас хасуулах талаар тайлагнан, баталгаажуулж илгээлээ.

Үйлчилгээний нэгдсэн төв нь Иргэдээ сонсох нээлттэй утас 70481111, мэдээлэл лавлагааны E-Mongolia цахим үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 8 өргөдөл ирснээс ажлын байртай холбоотой 3 өргөдлийг шийдвэрлэж, 5 өргөдөл нь хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 62.5 хувьтай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног байна.

Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор шийдвэрлэгдээгүй, хугацаа хэтэрсэн 1 өргөдлийн шийдвэрлэлтийн хугацааг 30 хоногоор сунган шалгаж байна. 2 өргөдлийн шийдвэрлэлтийн хугацаа хэтрэн судлагдаж байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” тусгай дугаар утсанд 2 дуудлагын мэдээллийг дэвтэрт бүртгэн, санал хүсэлтийг программд оруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэлээ.

Дэлхийн Зөн Олон улсын байгууллага, АНУ-ын USAID хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн цахим уулзалт 05 дугаар сарын 17-ны өдөр боллоо.

Уг цахим уулзалтад төсөл хэрэгжиж байгаа Бугат, Шарга, Дэлгэр сумдын болон аймгийн удирдлагууд, төслийн багийнхан оролцож, зорилтод сум, байгууллагуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааг эргэн дүгнэх, хийгдэх болон цар тахлын улмаас хойшилсон үйл ажиллагаануудын дахин төлөвлөлтийн талаар хэлэлцлээ.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2021 оны 4 дүгээр сарын танилцуулга, инфографикийг бэлтгэн аймгийн Статистикийн хэлтсийн вэб сайт болон фэйж хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэлээ. Мөн “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тогтоох судалгаа”-ны үр дүнгээр танилцуулга бэлтгэн гаргаж аймгийн удирдлагууд болон хэрэглэгчдэд хүргүүлээ.

## ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд нийт 239 захирамж гаргасан байна.

Сумдад баригдах 120 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын гэрээ болон бусад 8 ажлын гэрээг хянаж, санал хүргүүллээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар орон нутагт ажиллаж, аймгийн удирдлагууд болон Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Хилийн цэргийн 0214 дүгээр анги, Архивын тасгийн хамт олонтой уулзаж, ажлын нөхцөл байдалтай нь танилцлаа. Орон нутагт ажиллахдаа Цагдаагийн газарт 2 авто машин, 2 мотоцикль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1 автомашин, Улсын бүртгэлийн хэлтэст 1 автомашиныг тус тус шийдвэрлэж өглөө. Мөн Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Архивын тасгийн байрны асуудлыг шийдвэрлэлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж буй 1 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэж, мэдүүлэгт заасан холбогдох материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчиллээ.

Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн 66 лавлагааг гаргаж, 7 иргэний гадаад паспортын захиалга авч, 1 хуулийн этгээдийг шинээр, 1 хуулийн этгээдийг дахин бүртгэн гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжууллаа.

Иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 195 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, үйлчилгээний хураамж 4677.1, улсын тэмдэгтийн хураамж 89.7, татварын орлого 10887.7 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Тайлант хугацаанд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 18 иргэнд 360.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, иргэний бүртгэлийн чиглэлээр 811 бүртгэлд хяналт тавьж, 3 дүгнэлт гаргалаа.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тайлант хугацаанд шүүх эмнэлгийн 50 шинжилгээ хийснээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 41, хүний биед хийсэн бусад 5, цогцост 4 шинжилгээ хийсэн бөгөөд гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээгээр хүнд 2, хүндэвтэр 1, хөнгөн 7, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 10, гэмтэл тогтоогдоогүй 21 байна. Хэргийн газрын үзлэгт 4 удаа оролцож, 82 гэрэл зураг авч, объектын шинж тэмдгийг бэхжүүллээ.

Мөн эрүүгийн 3 хэрэгт 7 объектод 3 криминалистикийн шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 15 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 3, хулгай 2, хүчин 1, зам тээврийн ослын 2, бусад 7 хэрэгт үзлэг шинжилгээ хийсэн байна. Хэргийн газрын үзлэгээр 27 ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, баримтжууллаа.

**Цагдаагийн газар:** Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 648 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 198, зөрчлийн шинжтэй 464 гомдол, мэдээлэл байна. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 648 гомдол, өргөдөл, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 150 нэгжээр буюу 30,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 358 буюу 56,2 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хүлээн авсан гомдол, мэдээллийн 98,3 хувийг шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөд 151.2 сая төгрөгийн хохирол учирсан 82 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 16 хэргээр буюу 24.2 хувиар өсч, учирсан хохирол 223.9 сая төгрөгөөр буюу 60.0 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 82 гэмт хэрэгт нийт 66 хүн холбогдож, гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 33 хүн гэмтсэн байна.

Хөнгөн гэмт хэрэг 67 бүртгэгдсэн нь 21 нэгжээр буюу 45,6 хувиар, мөрдөн байцаалтын хэрэг 34 бүртгэгдэж 25 нэгжээр буюу 3,7 дахин тус тус өсч, хэрэг бүртгэлтийн хэрэг 48 бүртгэгдэж 9 нэгжээр буюу 16.0 хувиар, хүнд гэмт хэрэг 15 бүртгэгдсэн нь 5 нэгжээр буюу 25.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 41,7 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,1 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Улсын дунджаас 3,3 нэгжээр дээгүүр байна.

Нийгмийн хэв журам зөрчсөн 3746 зөрчил илрүүлэн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3944 буюу 51,3 хувиар, 3710 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3966 буюу 52.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 3528 иргэнийг 132101.0 мянган төгрөгөөр торгох, 83 хүнийг баривчлах, 94 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдууллаа.

Нийт зөрчлийн 247 буюу 64 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил үйлдсэн байна.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Төсвийн орлогын гүйцэтгэлийн 05 дугаар сарын мэдээг нэгтгэн боловсрууллаа. Орон нутгийн төсөвт 2955.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 3331.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 112.7 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 760.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 825.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 108.7 хувиар биелүүллээ.

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 05 дугаар сарын санхүүжилтыг хуваарийн дагуу сумдад 965.9 сая төгрөг, шууд харилцагч байгууллагуудад 744.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 2232.4 сая төгрөгийг тус тус олгосон. Аймгийн ОНХСангаас 4 төсөл, арга хэмжээнд – 454.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1 төсөл, арга хэмжээнд – 15.0 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

**Худалдан авах ажиллагаа:**Төлөвлөгөөний дагуу 9.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 20 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан ба худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгууллаа.

**Өмчийн асуудлаар:** Аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны эд хөрөнгийн бүргэлийн болон захиргааны статистик мэдээллийг холбогдох маягтын дагуу нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүллээ.

Нээлттэй дуудлагын худалдааг 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж 2 автомашиныг дуудлага худалдаагаар оруулж, төсөвт 4.5 сая төгрөг төвлөрүүллээ.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 1380.4 мянган хээлтэгч малтай бөгөөд төллөвөл зохих 864.6 мянган хээлтэгчээс 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 588.4 мянган мал төллөж, нийт 535.7 мянган төл бойжиж, мал төллөлт 68.0 хувь, төл бойжилт 91.0 хувьтай байна.

Том малын зүй бус хорогдол 187.4 мянган толгой буюу нийт малын 5.7 хувь нь байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2021 оны А/90 дугаар

захирамжийн дагуу “Говь-Алтай” үүлдрийн 3000 хонь, “Хөвчийн улаан” нутгийн 1500 ямаа, Дэлгэр сумд үржүүлж буй “Алтайн улаан” үүлдрийн Д хэвшлийн 3500 ямаа, Цогт сумд үржүүлж буй “Говь-Алтай” үүлдрийн 5000 хонь, “Мөнгөн сорт” нутгийн 1500 ямаа, нийт 14500 толгой малд технологит хугацаанд нь хаврын үзлэг ангилалтыг хийлээ.

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготныг тодотгох судалгааг хийхээр ХХААХҮ-ийн яамнаас ажлын хэсэг Есөнбулаг, Жаргалан, Цогт, Тайшир, Халиун, Эрдэнэ, Баян-уул сумдад ажиллаж байна.

ХХААХҮЯамнаас бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготныг устгах 32 тн бактержуулсан будааг татан авч Есөнбулаг, Жаргалан, Цогт, Тайшир, Халиун, Эрдэнэ, Баян-уул сумдад олголоо.

**Хүнс, газар тариалан, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:** “Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 5 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зохион байгуулж, зөвлөгөөнд аймгийн ЗДТГ, ХХААГ, “Хөдөө аж ахуйн Инноваци” ТББ-ын Зөвлөх баг, 18 сум 2 тосгоны удирдлагууд оролцлоо.

Хаврын тариалалтын ажил эхлэхтэй холбогдуулан ХХААХҮ-ийн яамнаас хаврын тариалалтад шарадлагатай төмс, хүнсний ногооны үрийн захиалгын дагуу төл сонгино 600 кг, шар лууван 50 кг, шар манжин 2.5 кг, хүрэн манжин 10 кг, урт сонгино 5 кг, тарвас 0,5 кг, бууцай 0.5 кг, өргөст хэмх 3 уут, лооль 0,1 кг, чинжүү 2 кг, сармис 200 кг ирж сумдын тариаланчдад захиалгын дагуу олгож байна.

Аймгийн хэмжээнд үр тариа 82 га, ногоон тэжээл 362 га, төмс 19 га, хүнсний ногоо 18 га, жимс жимсгэнэ 82 га, нийт 564 га-д тариалалт хийгдээд байна.

**Хүнсний нөөц:** Нөөцөд мах 5.2 тн, гурил 279.5 тн, гурилан бүтээгдэхүүн 18.3 тн, будаа 98.8 тн, сүү 22.1 тн, өндөг 1.4 тн буюу 18000 ширхэг, ургамлын тос 19.0 тн, төмс 57,3 тн, хүнсний ногоо 27.0 тн, элсэн чихэр 53.3 тн, давс 25.6 тн, цэвэр ус 24.9 тн тус тус байна.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын А/107 дугаар захирамжийн дагуу малын сэг зэм устгах, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 141266 малын сэг зэмийг устгаж, 56687 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна.

Үндэсний итгэмжлэлийн газрын лаборатори итгэмжлэлийн техникийн зөвлөлийн хурлаар мал эмнэлгийн лабораторийн итгэмжлэлийг 2 жилээр сунгалаа.

Шүлхий өвчний тандалт, шинжилгээний дээжийг 15 сумын 64 өрхөөс хүлээн авч 256 үхэр, 384 хонь, 384 ямаанаас дээж цуглууллаа.

Бигэр, Шарга сумдад галзуу, Дэлгэр сумд хонь, ямааны хамууны хачиг оношлогдож холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД  
БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Төгрөг, Эрдэнэ, Дэлгэр, Тайшир, Чандмань сумдын ажлын тоо хэмжээ, зураг төслийг хүргүүлж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зохион байгуулж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 30.0 сая төгрөгийн хөрөнгөөр Дэлгэр сумын Гуулин тосгоны Соёлын төвийн барилгын цахилгааны сүлжээг шинэчлэх ажлыг “Грийтволл ковер” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгууллаа.

“Эрдэнэт” ТӨҮГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд Цогт, Баянтоорой тосгон, Төгрөг, Алтай, Жаргалан, Дарив, Халиун, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг бага оврын цэвэрлэх байгууламжтай болгох, аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг өртгөтөх ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг тус тус боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, тус яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Барилгын хөгжлийн төвийн дэд захирал Б.Энхболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус аймагт ажиллаж, ГХБХБГазар, Ундарга-Алтай ААТҮГазрын болон аймгийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцан, барилгын салбарт тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өглөө.

Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3500 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн барилга, Хуучин Ардын дуу бүжгийн Алтай чуулгыг Багшийн хөгжлийн ордон болгон засварлах ажил, 1-р сургуулийн спорт заалны барилга, Цээл сумын цэцэрлэгийн дэд бүтцийн ажлуудад олгож ажлыг эхлүүллээ.

Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын судалгааг Барилгын хөгжлийн төвийн Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтэст [osnaah@gmail.com](mailto:osnaah@gmail.com) цахим хаягаар хүргүүллээ.

### **“Сумдын төвийн шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төсөл арга хэмжээний хүрээнд:**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчтэй гэрээ байгууллаа. Үүнд:

Сумдад баригдах бага оврын цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлыг 17.1 сая төгрөгөөр “Чанарын түншлэл” ХХК-аар мөн эхний ээлжинд баригдах Бигэр, Тонхил сумын 120 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах “ДНТ” ХХК, “Ди Ди Эй Жи” ХХК-аар гүйцэтгүүлэхээр тус тус гэрээ байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/87 дугаар захиарамжийн дагуу сумдад баригдах 120 айлын орон сууцны барилгын холболтын зураг төслийг боловсруулах ажлыг “Тоонот констракшн” ХХК-тай 16 сумын гэрээг баталгаажууллаа.

**Нийтийн аж ахуйн талаар:** Орон нутагт коронавирусийн голомт илэрч хатуу хөл тогтоосон хугацаанд ус түгээх 22 байрны кноп, цонх, цонхны тавцан, ус авах шланк болон шланкны тогтоогч зэргийг хуваарь гарган өдөр бүр хлорын идэвх өндөртэй жавелионы 5-10%-ын уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна.

**ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:**



**Эрүүл мэндийн чиглэлээр:** Төгсөлтийн дараах давтан болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж багц цагаа биелүүлсэн 11 эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн сунгалтын материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын чиг үүрэг ба кейс хэлэлцүүлэг зохион байгуулах аргачлал, Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ, Эрүүл мэндийн хөгжлийн түлхүүр сумын эрүүл мэндийн төв, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн дансны тохиргоо, бичилт хийх, “Коронавируст халдвартай гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, хяналт сэтгэл зүйн зөвлөгөө халдварын сэргийлэлт, хяналтын талаар мэдлэг олгох сургалт, Настанд зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага, Коронавируст халдварын эмчилгээ, оношилгоо, анхаарах асуудал цахим сургалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын танилцуулга, ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжих арга аргачлал зэрэг 8 сургалтад нийт 203 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар:** Tandalt.gerege.mn программд нэвтрэн Эмнэлгийн бүртгэл хэсэгт Ковид-19 халдвараар онош батлагдан хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн мэдээллийг оруулах болон эмнэлгээс гарсан талаар Нэгдсэн эмнэлэг, Эрдэнэ, Төгрөг, Тайшир, Цээл, Хөхморьт сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ковид-19 өвчнөөр нийт 282 хүн онош батлагдсанаас 191 хүн эмчлэгдэн эмнэлгээс гарсан байна. Одоо эмчлэгдэж байгаа 77 үйлчлүүлэгч байгаа ба эмнэлзүйн хувьд хөнгөн 58, хүндэвтэр 18, хүнд 1 байна.

Тайлант хугацаанд нэгдсэн эмнэлэгт 2386 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 37 байсан ба нас баралтын 1 тохиолдол гарлаа. Амбулаториар нийт 2155 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, томуу төст өвчинтэй 22 тохиолдол бүртгэгдлээ. Хүүхдийн тасагт 210 ор хоногийг ашигласнаас 3 хүнд хүүхэд эмчлэгдэж байна. Нийт 105 эх эсэн мэнд амаржиж, 106 хүүхдийг хүлээн авлаа. Түргэн тусламжийн 425 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 289 хүн өөрөө ирж үзүүлснээс 10 буюу 3.5% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын 8 тохиолдолд Рашаант, Наран багт, Жаргалан, Дэлгэр, Хөхморьт, Чандмань, Цээл сумд үйлчиллээ.

ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас бэлтгэн ирүүлсэн "Вакцин хийлгэхийн өмнө анхаарах зүйлс" сэдэвт видеог байгууллагын цахим хуудаст байршуулж, иргэдэд хүргэлээ.

Аймгийн Онцгой комисс, Алтайн мэдээ агентлагийн цахим хуудсаар шууд лайв нэвтрүүлгээр ковидын нөхцөл байдлын мэдээг өдөр бүрийн 10.00 цагт тогтмол хийж, иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд 210 удаа мэдээлэл оруулж, давхардсан тоогоор 2156 хүнд хүргэлээ.

**Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:** "Сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах" журмын төсөлд санал хүргүүллээ.

Цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай уялдуулан цэцэрлэгийн сургалт үйл ажиллагааг эхлэх дуусах хугацааг өөрчлөх тухай багш, удирдах ажилтнаас авах санал асуулгад нийт 176 албан хаагч хамрагдаж, дүнг БШУЯ-д хүргүүллээ. СӨБ-ын "Бэлтгэл" бүлгийн нийт 42 багш төсөлт тоглоомын аргагүйн төлөвлөлтийг хийж, аргагүйн шинэ санаагаа хуваалцаж, туршлага солилцлоо.

Гадаад хэлний 42 багшийг хамруулан "Мэргэжилтэн зөвлөж байна" онлайн сургалт явууллаа. ЭЕШ-н бэлтгэл унших даалгавар гүйцэтгэх стратегийн талаар зөвлөгөө өглөө. Мөн lingors хөтөлбөр, тоглоомд суурилсан арга зүйн сургалтыг ШУТИС багш нартай хамтран зохион байгууллаа.

Тайлант хугацаанд 5 дугаар ангийн 1049, 9 дүгээр ангийн 929, 12 дугаар ангийн 822 хүүхэд төгсөж, боловсролын гэрчилгээ, үнэмлэх олгогдлоо. Боловсролын салбарын мэдээллийн системд цэцэрлэгийн дэвшилт, төгсөлт, хичээлийн жилийн хаалт нээлт, сургуулийн төгсөлт, дэвшилт бүрэн хийгдлээ.

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/72 дугаар тушаалын дагуу аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулж, залуучуудын хөгжил оролцоог дэмжих, тэдний үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөлөө.

2021 оны 05 сарын 17-23-ны хооронд "АЛТАЙ ЭЕШ-2021" аяны хүрээнд 10 судлагдахууны хүрээнд нийт 24 ментор багш хичээл бэлтгэн зааж бие даан гүйцэтгэх дасгал, даалгавар өгч сорилго шалгалтыг авч ажиллалаа.

**Гэр бүлийн чиглэлээр:** Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гэр бүлийн сайн сайхныг дэмжих зорилгоор 3 болон түүнээс дээш хүү төрүүлсэн эхчүүдэд "Дархан бэр", 3-аас дээш охин төрүүлсэн ээжүүдэд "Хатан бэр" одон батламж олгож, хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг "Элэг бүтэн Монгол айл" төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 50 ээжид хүндэтгэл үзүүллээ.

Гэр бүлээрээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зөв дадал хэвшлийг бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Зөв бүхэн зөв дадлаас" цахим арга хэмжээг зохион байгууллаа.

Гэр бүлийн боловсрол олгох, "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй"-г түгээн дэлгэрүүлэх, сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр хүргэсэн 23 удаагийн постер бүхий зөвлөмж мэдээллийг нийт 60554 хүнд хүргэсэн байна.

**Залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 залууд 4 удаагийн 6 цагийн амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтыг цахимаар зохион байгууллаа.

Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачилгыг дэмжих, залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Гэр бүл,

хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг 25 гишүүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулж, тэргүүн, дэд тэргүүн, нарийн бичгийг сонгон бүрэлдэхүүнийг баталж анхдугаар хурлыг зохион байгуулаж, үйл ажиллагааг төлөвлөлөө.

**Хүүхдийн хамгааллын чиглэлээр:** Коронавирусийн халдвараар гэр бүлээрээ өвчилсэн 1 өрхөд 300,000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 5 дугаар сард хүүхдийн эрхийн зөрчлийн 5 дуудлага ирсэнээс 1 дуудлагыг хааж 4 дуудлагад хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Ковид-19 цар тахлын үед зорилтот өрхийн хүүхдүүдийн дархлааг дэмжих, халдвараас сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээний 300 хүүхдэд витамин, маск, санитол олгох ажлыг зохион байгуулж, 5 сум, 4 багийн хагас өнчин 52, хөгжлийн бэрхшээлтэй 23, бүтэн өнчин 7, архины хамааралтай гэр бүлд байгаа 25, нийт 53 өрхийн 107 хүүхдэд олгож эхлээд байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн Засаг даргын ивээл дор 100,000 төгрөгийн хадгаламж нээлгэх бүтэн өнчин хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, олголоо.

**Ажлын байрны захиалга, зуучлал:** Нийт 2 ААН байгууллагаас 122 ажлын байрны захиалга ирүүлснийг зуучиллаа.

**Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл:** Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 05 дугаар сарын санхүүгийн мэдээг гарган ХХҮЕгазарт хүргүүлсэн ба нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр 1176 иргэнд 332,0, асаргааны тэтгэмж 1008 иргэнд 90,2 сая, онцгой тохиолдлын амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 199 иргэнд 53,4 сая, ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж 43 иргэнд 6,1 сая, ХБИргэнд олгох хөнгөлөлт, тусламж 61 иргэнд 1,8 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 442 иргэнд 16,8 сая, цалинтай ээж тэтгэмж 2724 иргэнд 133,9 сая, нийт 5653 иргэнд 634,2 сая төгрөгийг олголоо.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** 46 даатгуулагчийн тэтгэмжийн материалыг цахимаар хүлээн авч, 1215 иргэнд утсаар, 288 иргэнд цахим сүлжээгээр зөвлөгөө мэдээлэл өгч, 389 ажил олгогчийн тайланг цахимаар хүлээн авлаа.

“Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх журмын тухай” хуулийн дагуу үнэт цаасыг иргэдэд хүргэх талаар НДЕГ-аас өгсөн чиглэлийн хүрээнд аймгийн хэмжээнд хуваарилагдсан 4730 иргэнд олгох ажлыг 5 сарын 7-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8550 иргэнд ХААН болон Төрийн банкаар 3212,1 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан 39, тахир дутуу 7, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 48 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 31 хүнд 49134.4 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 28 хүнд, оршуулгын тэтгэмж 4 хүнд 4.0 сая, ажилгүйдэлийн тэтгэмж 39 хүнд 27698.4 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 74 хүн хамрагдсанаас 31 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 8 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 354 иргэнийг хамруулж, 36.1 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 114 хүн орж, шинээр 17 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 127 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 4 хүн байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 26 иргэнд гаргаж үйлчиллээ.

#### ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

“Алтай Бороо-1” экспедици нь 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдөр ЦАЗН ажиллагааг явуулсанаар уулархаг нутаг болох Хасагт хайрхан уул, Далангийн нуруугаар цас, 8 сумдын нутгаар 0.2-2.0 мм хүртлэх хур тунадас орсон байна. Мөн цөлжилтийн мониторингийн ажиглалтын хүрээнд нийт 76 цэгээс 152 хөрсний сорьц авч химийн шинжилгээг 8 үзүүлэлтээр хийж Цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүллээ.

Чандмань сумын Улаан шалын хоолойд монгол бөхөн нутагшуулах ТЭЗҮ боловсруулах анхан шатны хээрийн үнэлгээ болон нэн ховор амьтанд зориулсан нарны өргүүртэй худаг гаргах байршлыг тогтоох судалгааны ажлыг ENSURE төсөлтэй хамтран гүйцэтгэж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 01 сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Сутай хайрхан уулын байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөөг 05 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Эрүүл ахуй, Эм био бэлдмэлийн хяналтаар: COVID-19 халдварт цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэх 12800 хүн тун БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн “Вероцелл” вакциныг эм биобэлдмэлийг хүлээн авах болон түгээлтэд хяналт тавьж ажиллалаа. Ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

АОК-ын шийдвэрээр эмийн сангууд хэвийн, хуваарийн дагуу ажиллах болсонтой холбогдуулан 9 эмийн санд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн, QR код байршуулж, эмийн сангаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 01/45 тоот удирдамжийн хүрээнд аймгийн төвд дархлаажуулалт хийж байгаа 4 түр цэгт эрүүл ахуй, эм био бэлдмэлийн чиглэлээр шалгалт хийхэд 1 түр цэгт 1 зөөврийн савны хэм хяналт 1.6 хэм, 1 түр цэгийн зөөврийн савны хэм хяналт 9.6 болсон зөрчил илэрснийг мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь арилгууллаа.

Хүргэлтээр үйлчилгээ үзүүлж буй эмийн сангуудад халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах талаар 6 заалт бүхий зөвлөмжийг цахимаар хүргүүлж,

хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. ХААН банкны бэлэн бус гүйлгээний киоск, орлогын АТМ-ыг ажиллуулах талаар зөвлөмж хүргүүлээ.

МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/95 дугаар удирдамжийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн хог хаягдал устгалд хяналт хийж 6 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн төвөөс 152 км-т байрлах Дарви сумын нутаг Далан түрүүнд шинжилгээ авах түр цэг зохион байгуулж, Ховд аймгийн Хилийн цэргийн дугаар ангиас халагдан ирсэн 102 цэргээс шинжилгээний түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авах ажилд хяналт тавьж ажиллалаа. Шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан болно.

Хүнсний чанар, стандартын хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 01/05, 01/48 дугаар удирдамжийн хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны 90, 92 дугаар захирамжийн дагуу хүнсний түгээлтийн үйлчилгээ үзүүлж буй худалдааны 7 ААН-д эрүүл ахуй, халдвар хамгаалал болон хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд зөвлөн туслах үйлчилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд хаяг шошгийн зөрчилтэй, үйлдвэрлэсэн хугацаа тодорхойгүй 8 нэр төрлийн 101 ширхэг, хэрэглээний баталгаат хугацаа дууссан 22 нэр төрлийн 94 ширхэг, нийт 657000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн акт үйлдэн хураан авч Есөнбулаг сумын ЗДТГ-ын дэргэдэх захиргааны зөвлөлд шилжүүлэхээр шийдвэрлэн зөрчлийг газар дээр нь арилгуулсан болно.

Зөрчлийн тухай хуулийн дагуу 4 аж ахуйн нэгжид шийтгэлийн арга хэмжээ ногдууллаа. Шошгын шаардлага хангахгүй, үйлдвэрлэсэн хугацаа тэмдэглээгүй бүтээгдэхүүн нийлүүлсэн Улаанбаатар хотод байрлах 2 компанийг шалгуулахаар НМХГ-т мэдээллээ.

Хүнсний худалдааны 62 нэгжид хяналт хийж, үйл ажиллагаа явуулж байсан 12 зөрчлийг илрүүлж, газар дээр нь арилгуулан, тусгаарлан ажиглах байр, вакцинжуулалтаар ажиллаж буй ажилчдын хоол үйлдвэрлэлд 2 удаа хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2021 оны А/146 дугаар захирамжийн биелэлтийг хүнсний худалдааны 32 газарт шалгаж, 112 зөрчил илрүүлэн 36 зөрчлийг газар дээр нь арилгуулж ажиллас ба QR кодгүй 13 газарт код үүсгэн байршуулж, худалдагч, үйлчлүүлэгч 26 иргэнд зааварчилгаа өгч ажиллалаа.

Авто засварын газар 3, авто сэлбэгийн газар 2, барилга угсралтын 1, бичиг хэргийн 1, нийт 5 ААН-д хяналт хийж, үйл ажиллагаа явуулж байсан зөрчлийг газар дээр нь таслан зогсоож, нийт 5 зөрчил илрүүлж, холбогдох хүмүүст зөвлөгөө өгч ажиллалаа.

ЭМГ-аас өгсөн чиглэлийн дагуу аймгийн Мал эмнэлгийн газраас Есөнбулаг сумын 13 байрны гадна талбай, 5 байрны 9 орц, 2 гудамжны, 2 автомашин, нийт 15490 м<sup>2</sup> талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, ЗӨСТ-өөс 4 объект 3320 м<sup>2</sup> талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, 37 объект 5260 м<sup>2</sup> талбайд

голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахад зөрчил илрээгүй болно.

Урьдчилан сэргийлэх шалгалтыг 8 үсчний газарт хийхэд 7 газар тусгай нөхцөл шаардлагыг хангахгүй байгаа тул улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд хуулийн хүрээнд дараагийн арга хэмжээг авахаар шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

#### **Гурав. Нэгдсэн лаборатори:**

Лабораторид 7 байгууллага, 2 аж ахуйн нэгж, 2 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 13 сорьц 50 үзүүлэлт, ундны ус 2 сорьц 27 үзүүлэлт, ариутгал халдваргүйтгэлийн бодисын 1 сорьц 2 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийхэд хүнсний бүтээгдэхүүний 1 сорьц 1 үзүүлэлт, ундны усны 1 сорьц 1 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр 56.8 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

